

Гарчиг

<i>БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</i>	3
1.1. <i>Ордын физик газарзүйн товч тодорхойлолт</i>	3
1.1.1. <i>Нийгэм эдийн засаг, дэд бүтэц, хүн ам</i>	4
1.1.2. <i>Ургамал, ан амьтаны аймаг</i>	4
1.1.3. <i>Байгал, цаг уур</i>	4
<i>БҮЛЭГ II. ОРДЫН ГЕОЛОГИ, ГЕОЛОГИЙН СУДАЛГАА</i>	5
2.1. <i>Ордын геологийн тогтоц</i>	5
2.2. <i>Давхарга зүй</i>	5
2.3. <i>Гүний чулуулаг</i>	5
2.5. <i>Тектоник</i>	6
2.6. <i>Геоморфологи</i>	6
2.7. <i>Гидрогеологи</i>	6
2.7.1. <i>Давхаргын нүх сүвийн ус</i>	6
2.7.2. <i>Ан цавын ба давхаргын ан цавын ус</i>	7
2.7.3. <i>Хувирмал чулуулаг дахь ус</i>	7
2.7.4. <i>Гүний чулуулаг дахь ус</i>	7
2.8. <i>Гидрогеологийн нөхцөл</i>	7
2.9. <i>Ордын нөөцийн тооцоо</i>	7
<i>БҮЛЭГ III. ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ</i>	9
3.1. <i>Уурхайн гүн, хүрээ хязгаар</i>	9
3.2. <i>Уурхайн ашиглалтын системийн сонголт, технологи</i>	9
3.3. <i>Уурхайн үндсэн хэмжээсүүд</i>	10
3.3.1. <i>Уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн</i>	10
<i>БҮЛЭГ IV. ДЭД БҮТЭЦ</i>	12
4.1. <i>Усны хэрэглээ</i>	12
4.2. <i>Уурхайн барилга, байгууламж</i>	14
4.3. <i>Уурхайн цахилгаан хангамж</i>	15
4.4. <i>Агуулах</i>	17
4.5. <i>Уурхайн харуул хамгаалалт</i>	17
<i>БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТООЦОО</i>	18

5.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт:	19
5.2 Байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт	20
БҮЛЭГ IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ.....	21
6.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	24
БҮЛЭГ VII. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31

БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Ордын физик газарзүйн товч тодорхойлолт

Цагаан Овоогийн хайлуур жоншны MV-18782А тусгай зөвшөөрөл бүхий орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт харьяалагддаг ба Улаанбаатар - Замын- Үүдийн чиглэлийн төмөр замын Айраг өртөөнөөс баруун урагш 35 км-т байрладаг.

MV-18782А Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүдийн солбицол

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүдийн солбицол

Д.д	Өргөрөг	Уртлаг
1	109° 4' 37.5 ^{II}	45° 39' 19 ^{II}
2	109° 4' 13.5 ^{II}	45° 39' 19 ^{II}
3	109° 4' 13.5 ^{II}	45° 39' 36.6 ^{II}
4	109° 4' 37.5 ^{II}	45° 39' 36.6 ^{II}



Зураг 1. Ордын байршил зург

Тус талбай нь мужлалын хувьд тал хээрийн бүсэд хамрах боловч говийн бүс рүү шилжих хэсэгт байрладаг. Гадаргуу нь намхан уул гүвээ толгод, хэрчигдэл багатай, өргөн хөндий хоолой хосолсон, газрын гадаргуугийн үнэмлэхүй өндөр нь 1040.0 м-1205.5 м-т хэлбэлздэг. Цагаан Овоогийн хүдрийн талбай нь 1210-1230 м-ийн үнэмлэхүй өндөрт байрладаг. Талбайн

усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөрөгийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн районы тектоник структурын чиглэлтэй давхцдаг. Чулуулгийн илэрц муухан харин талбайн хойд талаар рифейн хувирмал чулуулаг болон пермийн гүний чулуулгийн гаршууд сайтар илэрдэг бөгөөд бусад газарт дээрх насны чулуулгаас тогтсон жижиг толгод, гүвээнүүдийн орой хэсгээр гарш сайтай байдаг.

1.1.1. Нийгэм эдийн засаг, дэд бүтэц, хүн ам

Айраг сум нь сургууль, эмнэлэг, холбоо (үүрэн холбоо), худалдаа үйлчилгээ сайн хөгжсөн. Улаанбаатар хотоос 330 км хатуу хучилттай замаар, 35 км байгалийн шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Айраг сумын төв нь төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, Улаанбаатараас төмөр замаар 330км, Замын –Үүд өртөөнөөс 359 км байдаг. Тус сумын төвд өрөмдмөл гүний худаг байдаг ба усны чанар сайн, ундарга сайтай тул энэ районы ахуй хэрэгцээний усны гол эх үүсвэр болдог.

Тухайн дүүрэгт хүн ам сийрэг 1 кв.км талбайд 0,2-0,6 хүн ам ноогддог. Хамгийн олон хүнтэй нь Айраг сум 1500-2000 хүн амтай. Харин өнөөгийн байдлаар зундаа бусад газраас хүмүүс ирж хувиараа жонш олборлодог, эдгээр хувиараа жонш олборлогчдын тоо заримдаа 3000-5000 хүрдэг гэсэн мэдээ бий. Талбайн орчмоор цөөн тооны малчин өрхүүд зундаа нүүдэллэн ирдэг, тэдний өвөлжөө Хөх Өндөр уулын орчмоор байдаг.

Хар Айраг сумд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг ба хамгийн том аж ахуйн нэгж нь “Монросцветмет” нэгдлийн РЭП-ийн үйлдвэрлэлийн бааз, ачилтын талбай, механик засварын газар зэрэг үйлдвэрийн газрууд байна. Хүн амын ихэнх нь төмөр замын ажилчид байдаг. Үлдсэн цөөн хэсэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг.

1.1.2. Ургамал, ан амьтаны аймаг

Ургамлын бүрхэвч муутай, тачир сийрэг тал хэрийн өвстэй, энд тэнд алтан харгана, зэрлэг буйлсийн намхан бутнууд ургасан байдаг. Хөндий хуурай нууруудын захаар дэрс, шагшуурга ургадаг. Амьтаны аймаг олон төрөлтэй, араатан амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, мэрэгчдээс туулай, тарвага, олон төрлийн хулгана тааралдана. Хэвлээр явагчдаас бамбай толгойт могой, хонин ба могой гүрвэлтэй, жигүүртнээс бүргэд, элээ, тогоруу, харцага, сар, ногтруу, тагтаа элбэг тохиолдох ба нуур тогтсон үед ангир, нугас галуу түр байрладаг.

1.1.3. Байгал, цаг уур

Төслийн талбай нь цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн болон хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, жилийн дундаж хэм нь -2°. хамгийн хүйтэн нь 12-р сараас 2-р сарын эхэнд байдаг ба -28.5°-аас -32° хүртэл хүйтэрдэг харин хамгийн халуун сар нь 7-р сараас 8-р сар байдаг ба +23° +33°-ийн дулаантай юм. Жилийн хур тундасны хэмжээ 101 мм-343 мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85% нь зуны

улиралд бороо хэлбэрээр байдаг. Өвөлд 10- 20 мм-ээс хэтрэхгүй цас орно. Цасан бүрхэвчийн зузаан 5-8 см боловч зарим жилийнөвөлд цас ороогүй тохиолдол цөөнгүй байна. Анхны цас 10-11 сарын үед ордог ба 3- р сард хайлж дуусдаг. Агаарын чийгшилт зундаа 46-68%, харин өвөлдөө 60-65%-д хэлбэлздэг. Өвөлдөө хүйтэн боловч хур тундасгүй нарлаг цаг агаар зонхилдог, хавартаа мөн адил боловч салхи шуурга ихтэй. Хүйтний улиралд хөрсний хөлдөлт гадаргуугаас дунджаар 2-2.5 м ба олон жилийн цэвдэг байхгүй.

Хавар цагт бараг тогмол салхи шуургатай байдаг ба салхины хурд дунджаар 4.7 м/сек боловч зарим үед 14-18 м/сек, үе үе 20-24 м/сек хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг. Салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байдаг. Зуны ихэнх нь аагим халуун, харин сүүлрүүгээ бага зэрэг сэрүүсч, бороо хур элбэгшдэг. Намартаа сэрүүн салхитай нарлаг өдрүүд болж шөнөдөө хасах хэмтэй, өдөртөө дулаан цаг агаар зонхилдог.

БҮЛЭГ II. ОРДЫН ГЕОЛОГИ, ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

2.1. Ордын геологийн тогтоц

Цагаан Овоогийн жоншны орд нь Төв монголын атираат системийн Дунд говийн структур-тектоникийн бүсийн хүрээнд багтдаг Дорнод монголын хайлуур жоншны бүслүүрийн Хар-Айргийн хүдрийн зангилааны Баруун урд хэсгийн үргэлжлэл юм.

Дүүргийн геологийн тогтоцод рифейн хувирмал чулуулаг, дээд палеозой- мезозойн галт уулын болон галт уулын гаралтай тунамал чулуулгууд ба тэдгээрийг зүсэж гарч ирсэн янз бүрийн найрлагатай гүний чулуулгууд ордог.

2.2. Давхарга зүй

Талбайн давхарга зүйг бүрдүүлэгч чулуулагт доод дунд рифейн хувирмал чулуулаг, доод-дунд карбоны галт уулын гаралтай тунамал хурдас, дээд карбон-доод пермийн галт уулын чулуулаг, юрын галавын том ширхэгт тунамал хурдас, доод цэрдийн тунамал хурдас, дөрөвдөгчийн хуримтлалын сэвсгэр хурдас тус тус багтдаг.

2.3. Гүний чулуулаг

Цагаан Овоогийн талбайн дүүрэгт гүний чулуулгийн тархалт их, нийт талбайн 60% орчмыг эзэлдэг бөгөөд дүүргийн геологийн хөгжлийн түүхэнд дөрвөн удаагийн гүний чулуулгийн түрэлт үүссэнээс сүүлийнх нь бага интрузивын хөгжил явагджээ.

- Доод палеозойн гүний чулуулаг
- Пермийн гүний чулуулаг
- Дээд триас-доод юрын гүний чулуулаг
- Мезазойн дэл судлын чулуулаг

Метасоматоз хувирлуудад скарн, хайлуур жоншны эрдэсжилт ордог. Метасоматоз хувирал нь Хайлуур жонш, шохойлог найрлагатай хурдсуудыг даган үүсдэг ба талбайн хэмжээнд өргөн тархалттай хувирал юм

2.5. Тектоник

Судалгааны талбай нь Дундговийн өргөгдлийн ул суурийн хүрээнд багтдаг бөгөөд бүхэлдээ янз бүрийн цаг үеийн тектоник хагарал, эвдрэлийн хөгжлийн нөлөөгөөр блоклог бүтцийг үүсгэдэг. Өмнөх судлаачдын ажлын үр дүнгээр тухайн дүүрэгт 3 структур-формацын ярус ялгардаг.

- Каледоны буюу доод палеозойн ярус (доод)
- Герцины буюу дээд палеозойн ярус (дунд)
- Мезокайнозойн (Альпийн) давхардсан ярус (дээд)

2.6. Геоморфологи

Тухайн дүүрэг нь Дорноговийн төвийн өргөгдлийн бүсэд багтдаг Тал хээр, говийн бүсийн заагт оршдог зэргээс шалтгаалан геоморфлогийн элементийн өвөрмөц хөгжилтэй. Түүнчлэн эх газрын эрс тэс уур амьсгалтай, чулуулгийн хүчиллэг, шүлтлэг найрлага идэвхитэй тектоник хөдөлгөөний бүсэд багтдаг нь геоморфологийн ихээхэн нөлөө үзүүлжээ.

Судалгааны талбай нь намхан уулс толгод гүвээ, хөндий цайдмууд хосолсон гадаргуутай. Энэхүү геоморфологийн элементүүд нь ерөнхийдөө өргөгдлийн дагуу нарийн зурвас үүсгэн сунаж байрладаг. Үүнээс үзэхэд гадаргуугийн одоогийн хэвшинжийг Замын, Элгэн худгийн болон түүнтэй субпараллель хагарлууд тодорхойлж, тэдгээрийг хөндлөн огтолсон хагарлууд блоклог уул хөндийн гадаргууг үүсгэсэн ба дэл судлын хатуу чулуулгуудыг дагалдуулдгаараа дэллэсэн нуруудыг үүсгэсэн байна. Гадаргуугийн харьцангуй өндөршилт нь 50-100 м-ээс хэтрэхгүй алсуур налуу учир бүслүүрлэсэн геоморфологийн хөгжил энд бараг явагддаггүй.

2.7. Гидрогеологи

Тухайн дүүрэгт гадаргуугийн урсгал ус байхгүй, зөвхөн хур борооны үед эсвэл хавар цас хайлах үеэр гуу жалгуудаар түр зуурын горхи урсдаг ба жижиг хонхруудад түр зуурын жижиг нуур цөөрөм үүсдэг боловч удалгүй хатаж ширгэдэг. Ийм учраас дүүргийн хэмжээнд газрын доорх усны тухай яригдаж, судалгаа хийгддэг. Судлаачид тухайн дүүрэгт давхаргын нүх сүвийн болон ан цавын ба давхаргын ан цавын ус гэсэн 2 төрлийн газрын доорх усны эх үүсвэр ялгадаг. Байршил нөхцлөөр бүх газрын доорх усыг хөрсний ба даралтат ус гэж хуваадаг.

2.7.1. Давхаргын нүх сүвийн ус

Энэ нь дөрөвдөгчийн сэвсгэр хурдаст агуулагдах ус юм. Дөрөвдөгчийн хурдас дахь ус агуулагч давхарга нь пролюви-делювийн, салхины хурдсын ба нуурын хурдас бөгөөд тэдгээрийн элс, супесь, хурдасны зузаан нь 1-13 метрт хэлбэлздэг. Энэ төрлийн ус нь тухайн хурдас дотор тодорхой хэсэгт тархалттай ба голдуу хөндий хотгор хэсэгт цуглардаг, Хөрсний усны гүн нь 0-3 м. Ус нь ерөнхийдөө шорвогдуу амттай, тунгалаг, гидрокарбонат натрийн найрлагатай.

2.7.2. Ан цавын ба давхаргын ан цавын ус

Судалгааны талбайн дүүрэгт энэ төрлийн усыг дотор нь 3 хуваадаг.

Эффузив чулуулаг дахь ус: Галт уулын гаралтай дээд юра-доод цэрдийн хурдсын ус агуулагч комплекс. Тус хурдсын риолит, риолит-порфирын давхарга нь ус агуулдаг. Эффүзив чулуулаг дахь усны давхарга нь хэдэн метрээс 50-60 м-ийн гүнд байрладаг ба гүнд байрлах ус нь даралттай байдаг. Ус нь цэвэр тунгалаг 0.5-1,0 г/л эрдэсжилтэй. Химийн найрлагаараа гидрокарбонат-натрийн, кальц-натрын, хлорид- натрийн гэж ангилагддаг, ерөнхий хатуулаг нь 0.53-3.9 мг/экв.

2.7.3. Хувирмал чулуулаг дахь ус

Рифейн хувирмал чулуулаг дахь уст давхарга. Рифейн насны хувирмал чулуулаг нь талбайн хэмжээнд ихээхэн тархалттай, олон тооны том жижиг блоклог хэсгүүдийг үүсгэдэг ба ан цавшилт, бутралын бүсүүд нь харилцан адилгүй байршилтай бөгөөд түүний дотор гантигжсан Хайлуур жонш нь илүү их ан цавтай. Зарим хэсэгтээ карст үүсгэдэг тэдгээртээ ус агуулдаг байна. Гэхдээ энэ насны хурдсын усжилт их биш. Худаг дахь ундарга нь 0.1-0.3 л/сек-д хэлбэлзэнэ. Ус нь давсархаг амттай гидрокарбонат-хлорид-натрийн ба гидрокарбанат-натрийн-кальцийн бүлэгт хамаарна. Ерөнхий хатуулаг нь 2.4-8 мг/экв.

2.7.4. Гүний чулуулаг дахь ус

Доод ба дээд палеозойн гүний чулуулгийн ус. Талбайн хэмжээнд гүний чулуулаг ихээхэн тархалттай, түүний дотор гранит голлодог. Бүхий л гүний чулуулгууд ан цавшилт ихтэй тэдгээрээс тектоник эвдрэл, цавшилттай хэсэг нь илүүтэй ус агуулдаг. Гүний чулуулаг дахь газрын доорх ус нь энэ чулуулгийн ан цав ихтэй өгөршсөн гадаргууд ойрхон ба тектоник тасрал эвдрэлүүдийг даган нилээд гүн байрлалтай байдаг. Эдгээр гүний чулуулагт агуулагдах усны түвшин гадаргуугаас 0.5-30 м-ийн гүнд оршдог. Ундрага багатай, хамгийн их ундарга нь 0.1-1.0 л/сек-д хүрдэг. Усны дундаж хатуулаг нь 13.28 мг/экв. Усны найрлага нь гидрокарбонат-натрийн ба магний- кальцийн ангилалд хамаарна.

2.8. Гидрогеологийн нөхцөл

Хүдрийн биетийн тогтоц энгийн, унал суналынхаа дагуу тогтвортой, нэвтрэлтийн зэрэг сайн, газрын гадаргуугийн гипсометрийн төвшин 1040.0 -1205.5 м, далд аргаар ашиглахад гүний ус гарах хүндрэл байхгүй, агуулагч чулуулгаас хүдрийг ялган авахад хялбар зэрэг эерэг талууд ажиглагдана. Айргийн хүдрийн дүүргийн хайгуулын ба ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгж, орон нутгийн хувь хумүүс олон объект дээр гар аргаар 6-8 м хүртэл 75%-иас дээш агуулгатай ФК-75 маркийн жонш олборлодог байна.

Тус орд Айргийн хүдрийн дүүргийн бүсэд бусад ордуудтай харьцуулахад хэмжээгээр багавтар, энгийн тогтоцтой 4-р бүлгийн ордод хамаарагддаг. 1976 онд хийгдсэн геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр гүнрүүгээ хүдрийн биетийн зузаан болон хайлуур жоншны агуулга ихсэх хандлагатай гэжээ.

2.9. Ордын нөөцийн тооцоо

Албанбарга ХХК-ийн хийсэн хайгуулын ажлын үр дүнг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл 2009 оны 3-р сарын 26-ны өдөр хэлэлцсэнийг үндэслэн Ашигт малтмалын газрын дарга

2009 оны 04-р сарын 06 өдөр №78 тоот тушаал гаргаж, ордын нөөцийг дараах байдлаар бүртгэж, улсын нөөцөнд хүлээн авсан байна.

Хүснэгт 2. “Цагаан-Овоо ”-ийн ордын хайлуур жоншны нөөц

Блокын дугаар	Эзэлхүүн (м³)	Дундаж агуулга(%)	Эзэлхүүн жин (т/м³)	Геологийн нөөц (тн)	
				Хүдэр	Жонш
B-1	31357	60.05	2.6	81.528	48.957
C-1	19162	60.05	2.6	49.820	29.917
P	13972	60.05	2.6	36.327	-
B+C				131.348	78.874

Нөөцийн тооцооны үр дүнгээр 324 м урт, 4.99 м зузаантай, дунджаар 60.05%-ийн агуулгатай хайлуур жоншны судлын төрлийн жижиг ордын хүдрийн нөөцийг B+C зэрэглэлээр 78874 тонноор тооцсон байна. Тооцоонд хүдрийн биетийн уртыг хайгуулын 6 сувгаар бүхэлд нь хамруулж хайгуулын I-I, II-II, IV-IV шугамуудын хоорондын 120-160м зайтай гурван цооногийн үр дүнгээр нөөцийг тооцсон байна.

Нөөцийн тооцоонд тус орд нь бараг жигд агуулгатай судлын төрөлд хамаарагдах ба хажуугийн хүдэржилт 3-14%-д хэлбэлздэг, түүнчлэн дотроо хоосон чулуулгийн хольцгүй тул хүдэржилтийн итгэлцүүр хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн байна. Мөн түүнчлэн Цагаан Овоогийн жоншны орд нь зузаалаг бага ч суналын дагуу тогтвортой, бараг эгц буюу 75-85° уналтай, CaF₂ 60.05%, SiO₂ 26.0%, CaCO₃ 1.86% агуулгатай буюу кальцитийн модуль 2.96.

БҮЛЭГ III. ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

3.1. Уурхайн гүн, хүрээ хязгаар.

Цагаан Овоо хайлуур жоншны орд нь үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий хүдрийн зузаан дунджаар 3,5 ба урт нь 326м, гүн нь 25м зузаантай тогтож бодитой (В) зэрэгт хамаарах 81,5 мян.тн, боломжтой (С) зэрэгт хамаарах 49,8мян.тн, таамаг (Р) зэрэгт хамаарах 36,3 мян.тн хайлуур жоншны хүдрийн нөөц тогтоосон.

Ил уурхайн хүрээ хязгаарыг хөрс хуулалтын хязгаарын коэффициент-ийн хэмжээг баримтлаж В зэрэглэлийн хүдэрийн нөөцөд тулгуурлан тооцов. Хөрс хуулалтын хязгаарын коэффициентийг 1тн ашигт малтмал зарах үнэ, зардал зэрэгт тулгуурлан графо-аналитик арга ашиглан тогтоов.

MV – 0018728 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай хэмжээ нь 26.8 га талбайг эзэлдэг. Цагаан овоогийн ордын (В) нөөцийг ашигт малтмалын хуулийн дагуу бүрэн олборлохоор тооцов. Уурхайн оновчтой хүрээ хязгаарыг тогтооход В зэрэглэлийн нөөцийг олборлох явцад С зэрэглэлийн нөөцөөс 32154,4 тн хүдэр өртөж нийт (В+С) 113677.2тн хүдэр олборлоно.

Цагаан овоогийн хайлуур жоншны ил уурхайгаар ашиглах хил хязгаарыг дор тодорхойлов.

1. Баруун талаараа – суваг 12 оос баруун урагш 55.9 м
2. Хойд талаараа – суваг 2 оос баруун урагш 30.50 м
3. Зүүн талаараа – Лицензийн зүүн хилээс дотогш 36.34 м
4. Урд талаараа – Лицензийн урд хилээс дотогш 43.63 м

Ил уурхайн амсар техникийн хилээр 1.92 га талбайг эзэлнэ. Уурхайн гүн нь 1148.5 – р түвшингээс 1183 – р түвшин хүртэл 21 – 35м.

3.2. Уурхайн ашиглалтын системийн сонголт, технологи.

“Цагаан Овоо” орд нь уул-техникийн нөхцөлийн хувьд дараах онцлогтой

- Хүдрийн биет нь 75° - 85° градусын босоо уналтай
- Ордын ойролцоо усгүй, өрөмдлөгийн цоонууд 20-30м гүнд ан цавын болон нүх сүвийн усны түвшин тогтоосон бөгөөд энэ нь 0,01-0,05л/мин ундрагатай. Ашиглалтын явцад уурхайн ухагш орж ирэх усны шүүрэл маш бага байх тул уул техникийн хувьд хүндрэл учруулахгүй.
- Ордын гадаргын рельеф нь намхан толгой, хүдрийн биетийн дээд хэсэг нь уулын хажуу бэлд ил гарч тогтсон.
- Үндсэн чулуулгийн бат бөхийн коэффициент (М.М.Протоальяконов) $f=10-12$

Эдгээр уул-техникийн онцлог нөхцөл, зэргийг үндэслэн өрөмдлөг тэсэлгээний ажлаар чулуулгийг урьдчилан сийрэгжүүлж, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөв.

Уурхайн хажуугийн өнцөг. Цагаан Овоогийн хайлуур жоншны ордын хувьд 75° - 85° градусын босоо уналтай, хүдрийн биет газрын гадаргууд ил гарсан, гүн нь бага байгаа учраас ил аргаар ашиглах боломжтой. Олборлолтын үед хөрс хуулалтын коэффициентийг бага

байлгах үүднээс эдийн засгийн хувьд ашигтай ил уурхайн хажуу, доголын өнцгийг тогтоох нь нэн чухал юм.

Хүснэгт 8. Ил уурхай хажуу ба доголудын налуугийн өнцгийн баримжаа хэмжээ. (“Гипроруда”-гийн баримтлал)

Чулуулгийн бат бөхийн тодорхойлолт	Чулуулгийн бат бөхийн коэффициент	Доголын хажуугийн налуугийн өнцөг, град	Ил уурхайн гүнээс хамаарах хажуугийн налуугийн өнцөг, град			
			90м	180м	240м	300м
Дээд зэргийн бат бөх чулуулаг	15-20	75-80	60-68	57-65	53-60	48-54
Бат бөхдүү чулуулаг	8-14	65-75	50-60	48-57	45-53	42-48
Дунд зэргийн бат бөх чулуулаг	3-7	55-65	43-50	41-48	39-45	36-43
Зөөлөн ба зөөлөндүү чулуулаг	1-2	40-55	30-43	28-41	26-39	24-36
Зөөлөн ба шороо	0,6-0,8	25-40	21-30	20-28	-	-

Уурхайн хүрэн дэх нийт жоншны хүдэр, агуулагч чулуулгуудын бат бөхийг дундажлан, тэдгээрт тулгуурлан “Гипроруда”-гийн баримтлалыг ашиглан доголын хажуугийн өнцгийг 75° - , ажлын бус доголын хажуугийн өнцгийг - 65° , ажлын бус доголын өндрийг 5м, аюулгүйн бермийг 1,5м, уурхайн хажуугийн өнцгийг – 52° байхаар эцэслэн тооцов.

3.3. Уурхайн үндсэн хэмжээсүүд

Монгол улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн хувьд тусгай зөвшөөрлөөр олгосон талбайд бүрэн багтаж байгаа учир ил уурхайн хүрээ хязгаарт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Өөрөөр хэлбэл ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн хилээс гадагш газрыг эвдрэлд оруулахгүй. Уурхайн хүрээ хязгаарыг тогтоохдоо бүртгэгдсэн нөөцийг аль болох иж бүрэн ашиглах зорилт тавьж ордын тогтоогдсон нөөцийг бүрэн олборлох юм.

Уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн, уурхайн ёроолын өргөнийг аюулгүй байдлын үүднээс тогтоох тодорхойлох шаардлагатай. Уурхайн ёроолын өргөнийг экскаваторын ажиллах нөхцөл, тээврийн хэрэгсэлийн ажиллагааны нөхцөлийг харгалзан тооцов.

3.3.1. Уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн.

$Bat.min = A_n + C + B_{x3} + C_1 + Z = 15,19 + 2 + 0,5 + 0,5 + 3 = 21,19$ м Үүнд : A_n -нурлын өргөн, м

C - доголын доод ирмэгээс хөдөлгөөний зурвас хүртлэх зай, м

B_{x3} –хамгаалалтын зурвасын өргөн, м

C_1 –нөөц зурвасын өргөн,м

Z – Нурлын призмийн өргөн, м

1. Уурхайн ёроолын өргөн. Уурхайн ёроолын өргөн нь олборлолтын тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл, автосамосвалын ажиллагааны нөхцөлийг харгалзан тооцов.

$$b=B+1(B+L)+2C=2,495+1(2,49+7,5)+2*2=13,95$$

Хүснэгт 9. “Цагаан-Овоо”-ийн ил уурхайн үндсэн хэмжээсүүд

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс
1	Ажлын доголын өндөр	м	5
2	Ажлын доголын хажуугийн өнцөг	м	75 ⁰
3	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	65 ⁰
4	Доголын налуу траншейн өргөн	м	8
5	Траншейн налуугийн өнцөг	°/∞	80
6	Доголын аюулгүйн бермийн өргөн	м	1.5
7	Тээврийн бермийн өргөн	м	8
8	Уурхайн ёроолын өргөн	м	14
9	Ажлын талбайн хамгийн бага өргөн:	м	21.19
10	Овоолгын доголын хажуугийн өнцөг:	град	30-33 ⁰
11	Овоолгын доголын өндөр:	м	10

БҮЛЭГ IV. ДЭД БҮТЭЦ

Цагаан Овоогийн хайлуур жоншны ордод хамгийн ойр буюу 35 км-т орших Айраг суманд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг ба хамгийн том аж ахуйн нэгж нь “Монголросцветмет” нэгдлийн РЭП-ийн үйлдвэрлэлийн бааз, ачилтын талбай, механик засварын газар зэрэг үйлдвэрийн газрууд байна. Хүн амын ихэнх нь төмөр замын ажилчид байдаг. Үлдсэн цөөн хэсэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг. Цагаан Овоо хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын 3-р багийн нутаг дэвсгэрт байрладаг. Ордын бүсэд хөдөлгөөнт холбооны Мобиком, Жи–мобайл зэрэг сүлжээнүүдийн байнгын ажиллагаатай дэд бүтэц хөгжсөн.

4.1. Усны хэрэглээ

Цагаан Овоогийн хайлуур жоншны орд нь Монгол орны Умард говийн гүвээт сав газарт хамаарагдах бөгөөд ойр орчимд ил усны тогтолцоо болох ундны ус, гол горхи, булаг шанд байхгүй. Уурхайн усны хангамжыг айраг сумын төвөөс зориулалтын усны машинаар тээвэрлэн хэрэглэнэ.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт гадаргын ус 1420 төг/м^3 газар доорхи ус 3700 төг/м^3 тус тус байдаг. Ус ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг хотхоны усны хэрэглээнд 0.25, уурхайн зам усалгаа тоосжилтод 1.8-аар тус тус тооцов.

Цагаан Овоо хайлуур жоншны уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. Төслийн хүрээнд нийт усны зардал

Д.д	Тодорхойлолт	Усны зарцуулалт							Зардал						
		Х.н	Ашиглалтын жилүүд					Нийт	Х.н	Ашиглалтын жилүүд					Нийт сая.төг
			1	2	3	4	5			1	2	3	4	5	
1	Хотхоны усны хэрэглээ	мян м3	0.21	0.21	0.21	0.21	0.21	1.06	сая төг	0.20	0.20	0.20	0.20	0.20	0.98
2	Зам усалгаа тоосжилт	мян м3	0.32	0.32	0.32	0.32	0.32	1.58	сая төг	0.42	0.42	0.42	0.42	0.42	2.10
	Нийт		0.53	0.53	0.53	0.53	0.53	2.63		0.62	0.62	0.62	0.62	0.62	3.08
Усны нийт хэрэгцээ															
5	Жилийн усны хэрэгцээ	м3/жил	0.53	0.53	0.53	0.53	0.53	2.63	сая төг	0.615	0.615	0.615	0.615	0.615	3.08
6	Хоногийн усны хэрэгцээ	м3/хон	3.90	3.90	3.90	8.78	8.78	3.90		0.005	0.005	0.005	0.005	0.005	0.02
7	Цагийн усны хэрэгцээ	м3/цаг	0.39	0.39	0.39	0.88	0.88	0.39							
8		л/с	0.11	0.11	0.11	0.24	0.24	0.11							

Уурхайн жилийн нийт усны хэрэгцээ 0.55 мян.м3, нэг хүнд ногдох өдрийн ахуйн хэрэглээний ус 58 л байхаар байна.

4.2. Уурхайн барилга, байгууламж

Уурхайд иргэний ба үйлдвэрлэлийн доор тусгасан барилга, байгууламжууд баригдана.

Хүснэгт 2. Уурхайн барилга байгууламж

Д/д	Барилга, байгууламж	Марк	Хэмжээ	Нэгж үнэ, сая төг.	Нийт үнэ, сая төг.
1	Халуун усны байр, м ²	Сендвич	70	0.7	49
2	Уурхайн оффис	Сендвич	40	2	80
3	Тэсрэх бодисын агуулах, м ²		60	0.5	30
4	Хоолны газар, м ²	Сендвич	80	0.7	56
5	Засвар механикийн цех /сэлбэг/, м ²	контейнер	2	2.5	5
6	Ажилчидын сууц	гэр	6	2	12
7	Агуулах	контейнер	2	3	6
8	Бусад		10%		25.2
	Дүн				277.2

Уурхайн барилга байгууламжинд нийт 277.2 сая төгрөгийн хөрөнгө шаардагдаж байна.

4.3. Уурхайн цахилгаан хангамж

Цагаан Овоогийн хайлуур жоншны уурхайн гол цахилгаан хэрэглэгчид нь уурхайн засвар механикын газар, хотхоны хэрэглээ, гал тогоо, халуун ус зэрэг болно.

Уурхайн цахилгаан эрчим хүчний зарцуулалт ба хүчин чадлын хэрэгцээний тооцоог хүснэгт 32 -д үзүүлэв.

Хүснэгт 3. Уурхайн цахилгаан эрчим хүчний зарцуулалт ба хүчин чадлын хэрэгцээний тооцоо

Д/д	Цахилгаан хэрэглэгчийн нэр	Тооцооны актив ачаалал, кВт	Хоногт ажиллах цаг	Жилд ажиллах хоног	Жилд ажиллах цаг	Цаг ашиглалтын итгэлцүүр	Актив цахилгаан энергийн жилийн зарцуулалт, мян.кВт.ц	
А. Засварын цех								
1	Точел М3335	1.125	10	142	1420	0.8	1.278	
2	Өрмийн суурь машин Z4116	1.54	10	142	1420	0.8	1.7	
3	Токарийн суурь машин СА6240В D400*1500	1.168	10	142	1420	0.8	1.3	
4	Хийн компрессор	5.5	10	142	1420	0.8	6.2	
5	Тасдагч LW6B-126	0.84	10	142	1420	0.8	0.9	
6	Гагнуурын цахилгаан аппарат ВХ3-500-Ү2	8.97	10	142	1420	0.8	10.2	
	Дүн В	19.1					21.7	
Б. Хотхон								
1	Захирааны байр	Үндсэн гэрэлтүүлэг	0.36	6	153	918	0.9	0.30
2		Ослын гэрэлтүүлэг, Цэнэглэдэг гэрэл	0.18	0.1	153	15.3	1	0.00
3		Эйр кондишнер	4.8	8	153	1224	0.8	4.70
4		Залгуурууд	2.5	6	153	918	0.75	1.72
5		Компьютер	0.8	6				
6	Ажилчдын	Үндсэн гэрэлтүүлэг	0.72	12	153	1836	0.9	1.19
7		Ослын гэрэлтүүлэг, Цэнэглэдэг гэрэл	0.36	0.1	153	15.3	1	0.01
8		Залгуурууд	10	6	153	918	0.75	6.89
9		Эйр кондишнер	9.6	8	153	1224	0.8	9.40
10	Гал тогоо	Халуун тогоо	10.2	10	153	1530	0.8	12.48
11		Залгуурууд	7.92	10	153	1530	0.75	9.09
12		Үндсэн гэрэлтүүлэг	0.29	10	153	1530	0.9	0.40
13		Ослын гэрэлтүүлэг, Цэнэглэдэг гэрэл	0.14	0.1	153	15.3	1	0.00
14		Пилетик	4.8	10	153	1530	0.8	5.88
15		Эйр кондишнер	0.13	10	153	1530	0.8	0.16
16	А	Үндсэн гэрэлтүүлэг	1.08	10	153	1530	0.9	1.49

Цагаан Овоо хайлуур жоншны уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

17	Ослын гэрэлтүүлэг, Цэнэглэдэг гэрэл	0.43	10	153	1530	1	0.66
18	Ус халаагуур	7.6	10	153	1530	1	11.63
19	Угаалгын машин	7.74	10	153	1530	0.8	9.47
20	Хатаагуур	8.6	10	153	1530	0.8	10.53
	Дүн С	78.25					85.98
	Нийт	97.39					107.73

Цагаан Овоогийн хайлуур жоншны ил уурхайн цахилгаан хангамжинд дизель станц хэрэглэхээр төсөлд тусгав. Уурхайн цахилгааны хүчин чадлын хэрэгцээний тооцоогоор суурилагдсан чадал 97.39 кВт болно. Төслөөр VOVAC – VC100GF маркийн дизель цахилгаан станцыг нэгийг байнга ажиллуулан, нэгийг нөөцөд байхаар тооцоо хийлээ.

Eastern lion



Зураг 1. VOVAC – VC100GF

Цахилгаан эрчим хүчний жилийн зарцуулалт 107.7мян.кВт цаг байна. Дизель цахилгаан үүсгүүр нь уурхайн хотхоны талбайд байрлах бөгөөд барилга байгууламжаас 100м зайд байрлана. Дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан хэрэглэгчийн хамгийн хол зай нь 0.7 км байх тул, дизель цахилгаан үүсгүүрээс хэрэглэгч хүртэл 0.4 кв-ийн агаарын шугамаар холбон эцсийн шонгоос цахилгаан хэрэглэгчид ШРПС3х1 кабелиар тэжээгдэж

байхаар төсөлд тусгав. Цахилгаан эрчим хүчний хангамжинд шаардагдах хөрөнгө оруулалтын зардлыг хүснэгт 0-5-д үзүүлэв.

Хүснэгт 4. Цахилгаан эрчим хүчний хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо	Нэгж үнэ, мян.төг	Нийт үнэ, сая.төг
1	Дизель станц, VOVAC – VC100GF	2ш	20000.0	40.0
2	0.4 кВ-ийн агаарын шугам	2км	5500.0	11.0
3	Бусад тооцоологдоогүй, 5%			2.55
	Бүгд дүн			53.55

Уурхайн цахилгаан эрчим хүчний хангамжид нийт 53.55 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгцээтэй байна.

4.4. Агуулах

Шатах тослох материалын агуулах: Цагаан Овоогийн хайлуур жоншны орд нь дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн бүсэд байрших тул уурхайн түлшний эргэлтийн нөөцлөлтийг 15 хоногоор тооцсон. Уурхайн түлшний зарцуулалт хоногт дунджаар 1 тонн байх ба уурхайд хадгалах түлшний нөөц 15 тонн байна. Түлш болон шатах тослох материалыг галын аюулгүй байдал хангасан, тусгай контейнерт, ил уурхай болон ажилчдын хотхоноос 1 км зайд хадгална. Байршлыг уурхайн генпланд үзүүлсэн. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна. Түлшийг тусгайлан бэлтгэсэн талбайд 1 ш ёмкостод хадгална. Шатах тослох материалын агуулахын хэрэгцээт талбай 746.2м^2 байна.

Сэлбэг материалын агуулах: Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материалын агуулахад зориулж дулаалга бүхий 20 тн –ын контейнер 1ш – ийг төсөлд тусгав.

Тэсрэх материалын агуулах. Цагаан Овоогийн ил уурхайн тэсрэх материалын агуулахын аюулгүйн байршлыг тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг баримтлан тооцов.

Тэсрэх материалын агуулахыг хагас гүнзгийрүүлсэн байдалтай, дөрвөн долоо хоногийн нөөцтэй лицензийн талбайн баруун хойд буланд байршуулна. Уурхайн хотгоноос баруун хойш 163м зайд, ШТМ агуулахаас 188,5м зайд байрлана. Уурхайн хотхонд байрлах дизель станцаас 0.4кВ –ийн цахилгаан дамжуулах агаарын шугам татаж цахилгаанаар хангана. Тэсрэх материалын агуулахын эзлэх нийт талбай 0.1га.

Тэсрэх бодисын агуулахаас барилга байгууламж хүртлэх аюулгүйн зайн ($R_{аз}$) зөвшөөрөгдөх хэмжээ.

$$\text{Гүнзгийрүүлсэн. } R_{аз} = \sqrt{Q}=77.45\text{м}$$

$$\text{Ил барьсан. } R_{аз} = 2 * \sqrt{Q}=154.9\text{м}$$

Энд: Q – Агуулахад тэсрэх материал хамгийн их хадгалагдах үеийн хэмжээ.

4.5. Уурхайн харуул хамгаалалт

Уурхайн хамгаалалтыг гэрээт хамгаалалтын албаар гүйцэтгүүлэх ба уурхайн аюулгүй байдлыг 4 хүний бүрэлдэхүүнтэй баг өдөр, шөнийн цагаар ээлжлэн сахиулахаар

төлөвлөсөн. Хамгаалалтын постыг генпланд үзүүлэв.

БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТООЦОО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжих “Цагаан Овоо”-ийн Хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” –ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Алтанбарга” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОНХЯ-наас /хуучин нэрээр/ 2018 онд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрт төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг

тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

БОМТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх, БОМТ-ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх ёстой.

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг уурхай хаагдах үед хаалтын зардалд тооцохоор төлөвлөсөн болно.

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Алтанбарга” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол цехийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно

5.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт:

Хайлуур жонш олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, кареер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, буталж ангилан ялгаж угаах, үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрж бохирдохоос гадна тоос гэх мэт агаарт дэгдэх, шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Бохирдолын эх үүсвэр нь шороон авто зам, бутлан ангилж угаах процесс, түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (тоос, бохир ус, угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг орно.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт:

Ашигт малтмалыг нь авсан хэн бүхний, эх дэлхийгээ хайрлан хамгаалж эвдсэн орчноо нөхөн сэргээх, төлжихөд нь туслах нь бидний үүрэг зорилго бөгөөд зүйн хэрэг мөн болно.

5.2 Байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд Цагаан Овоо Хайлуур жоншны ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нөхөн сэргээх төсөл.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагийн нөсөр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал, уурхайн дарга, инженерүүд харуйцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажилна.
- Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсөний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө.
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажилгааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

4.3. Байгаль орчныг хамгаалах талаар мөрдөгдөж байгаа үндсэн стандартууд

1	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 4918:2000, MNS 4919:2000 оронд
2	MNS 5915:2008 Сэргээн сайжруулах. Эвдэрсэн газрын ангилал.
3	MNS (ISO) 4226:2000 Агаарын чанар. Ерөнхий ухагдахуун. Хэмжих нэгж
4	MNS 4585:2007 Агаарын чанар. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
5	MNS (ISO) 4867:1999 Усны чанар – Дээжлэх – Хэсэг 3:Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж
6	MNS 3342:1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
7	MNS 3597:1983 Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргын ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
8	MNS (ISO) 5667-11:2000 Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг: Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгдэх уснаас дээж авах заавар
9	MNS 0900:2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
10	MNS 4943:2011 Хүрээлэнбуйорчинднийлүүлэхцэвэршүүлсэнбохирус. Ерөнхийшаардлага.
11	MNS 4047:88 Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам
12	MNS 4288:95 Усны чанар. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага. Техникийн ерөнхий шаардлага
13	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооно.
14	MNS 4943:2000 Ус болон хөрсөнд хаяж болох үйлдвэр ахуйн хаягдал бохир усны бохируудуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж бусад үзүүлэлтийн хязгаарыг тогтооно.
15	MNS 3297-91. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
16	MNS 3342:1982 Гүний усыг хамгаалах ерөнхий шаардлага
17	MNS 3597:1983 Гүний усаар тэжээгдэж буй гадаргуугийн усыг хамгаалах тухай ерөнхий шаардлага

5.2 Байгаль орчин дүүцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил

2023 онд Цагаан Овоо хайлуур жоншны уурхайд нөхөн сэргээлтийн ажил хийхгүй. Уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн олборлолтын ажил дууссаны дараа хийж уурхайг хаана. Иймд 2023 онд Айраг сумын засаг даргын тамгын газраас дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлаар Айраг сумын Цагаан Дэлийн агуйн ойр орчимд 1га талбайн нөхөн сэргээх ажлын хэмжээ төлөвлөсөн болно.

Дүйцүүлэх хамгаалах нөхөн сэргээлтийн Цагаан Дэлийн агуйн талбайн байршлыг орон нутгийн газар харилцан уулзалт хийж эцэслэн шийдвэрлэхээр болсон.



Зураг 2. Цагаан дэлийн агуй

БҮЛЭГ IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ**Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал**

Хүснэгт 5

Болзошгүй нөлөөллүүд	сөрөг	Нөлөөллийг бууруулахарга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин					
Уурхай орчимд тоосжилт үүсэх		Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Үйл ажиллагааны турш	2 000.0	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшинстандарт MNS 5916:2008
		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Жилд 2 удаа	ОХШХ-ийн зардлаас	
Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүснэ.		Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Авто машины тээвэр хийх үед	1 500.0	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшинстандарт MNS 5013:2003 Бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 Дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Газрын гадарга, хэвлий					
Уурхай дахь Хайлуур жоншг олборлож, газрын гадаргад цоо шинэ хотгор гүдгэрийн хэлбэр үүсгэнэ.		Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх	Уурхай ашиглалтын төгсгөлд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Хөрсөн бүрхэвч					
